

Маргааны товч

“Зэмүүжин” ХХК-аас “XV-018001 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй байгаа хууль бус эс үйлдэхгүйг тогтоож, XV-018001 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахыг Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтэст даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ.

Анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн. Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах журмаар гомдол гаргаж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.